

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД, МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 5 дүгээр
сарын 20-ний өдөр

Дугаар А/102 / А-177

Улаанбаатар хот

Төлөвлөгөө, журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.2 дахь заалт, 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолын 1.1 дүгээр зүйл, Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Алт-2” үндэсний хөтөлбөр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн А/66, А/202, А/174, А/166 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг тус тус үндэслэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн 7 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.“Алт-2” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр, “Алт-2” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор олгох хөнгөлөлттэй санхүүжилтийн түр журмыг хоёрдугаар, Алт агуулсан хүдэр, элс олборлон баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон шаардлагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Мөнхтөр), Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (Х.Хэрлэн)-д тус тус даалгасугай.



2020 оны 5

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Монголбанкны Ерөнхийлөгчийн
2020 оны 5 дугаар сарын 28 өдрийн 102/А-177 дугаар
хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

“АЛТ-2” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго	Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн богино хугацааны /2 жил/ тогтвортой хөгжлийг хангаж алт олборлох, баяжуулах үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтрүүлэх замаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үр дүнг сайжруулах, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангаж, “Алт-2” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд энэхүү төлөвлөгөөний зорилго оршино.					
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)	Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлж 2020 онд 23 тн, 2021 онд 25 тн хүргэж, цаашид алтны олборлолтын хэмжээг тогтвортой түвшинд байлгана.					
Үйл ажиллагааны чиглэл	Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл: Алт агуулсан хүдэр, элс олборлох, баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдах ажиллагааны бүртгэлжүүлэлт, хяналт, үзлэг, шалгалт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, алт агуулсан ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, олборлолт хийгдсэн талбайг нөхөн сэргээх, алтны уурхайн хаалттай холбоотой үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх					
Д/д	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа (давтамж)
1.	Алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх	- Алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй санхүүжилт олгох, - шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх	Шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгосон байх	Монголбанк,	УУХҮЯ, АМГТГ	2020, 2021 оны эхний хагас жилд

2.	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэх	- Алт олборлох төслүүдийн эрчимжүүлэх хүрээнд орд ашиглах ТЭЗҮ-ийн төсөл, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөөний төсөл, уулын ажлын тайлан, төлөвлөгөөг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэх	Төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, шуурхай болсон байх,	УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ	Төсөл хэрэгжүүлэгч ААН	Тухай бүр
3.	Орон нутагтай хамтран ажиллах гэрээг шуурхай байгуулж, тогтвортой ажиллах бололцоог хангах	- Орон нутагтай хамтран ажиллах гэрээг шуурхай байгуулахад төрийн зүгээс дэмжлэг үзүүлж, тогтвортой ажиллах бололцоог хангах,	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ шуурхай байгуулагдсан байх	УУХҮЯ Орон нутгийн удирдлага	АМГТГ	2020, 2021 оны эхний хагас жилд
4.	Алтны үйлдвэрлэлд орон нутгийн зүгээс үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй болгох	- Нутгийн захиргааны байгууллагын төрийн үйлчилгээг шуурхай, зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх	Үйлчилгээ сайжирч, шуурхай болсон байх,	УУХҮЯ, Орон нутгийн удирдлага	АМГТГ	Тухай бүр
5.	Алт агуулсан хүдэр, элс олборлох, баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай	- Алт агуулсан хүдэр, элс олборлох, баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон	Шаардлагын хэрэгжилт	АМГТГ	УУХҮЯ, МХЕГ	Тухай бүр

	холбогдосон харилцааг зохицуулах	худалдахтай холбогдсон харилцааг зохицуулах шаардлагын хэрэгжилтийг хангах,	хангагдсан байна			
6.	Алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажилд дэмжлэг үзүүлэх	- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах, ашиглах зөвшөөрөл авах ажиллагааг шуурхай шийдвэрлэх,	Төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, шуурхай болсон байх,	БОАЖЯ	Холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд	Тухай бүр
7.	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг газар дээр нь өгч, үзлэг, хяналт хийх	- Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус томилолтоор ажиллаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг газар дээр нь өгч, уулын ажилд үзлэг, хяналт хийх	Уулын ажилд технологийн горимын дагуу явагдаж байх,	АМГТГ	УУХҮЯ, МХЕГ	Төлөвлөгдөн хугацаанд болон тухай бүр
8.	Мэдээллийн сан бий болгох	- Алтны олборлолт, худалдаа, Монголбанкны сар бүрийн алтны худалдан авалтын тухай мэдээллийг нэгтгэх	Мэдээллийн сан үүссэн байх	УУХҮЯ АМГТГ, Монголбанк	Төсөл хэрэгжүүлэгч ААН	7 хоног тутам

9.	Алтны олборлолт хийгдсэн талбайг нөхөн сэргээх, алтны уурхайн хаалттай үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх	- Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг мөрдөж ажиллах	Журмын хэрэгжилтийг хангасан байх	УУХҮЯ	БОАЖЯ, АМГТГ, МХЕГ	Тухай бүр
----	--	--	-----------------------------------	-------	--------------------	-----------

--- оОо---

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
Монголбанкны Ерөнхийлөгчийн
2020 оны 32 дугаар сарын 22 өдрийн 402/А-177 дугаар
хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

“АЛТ-2 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ОЛГӨХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ САНХҮҮЖИЛТИЙН ТҮР ЖУРАМ”

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Коронавируст халдвар/Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.2 дахь заалт, 10.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор худалдан авах нөхцөлтэйгөөр банканд зээл олгох, зээлийн төрөл, нөхцөл, зээл олгоход баримтлах зарчмыг тогтоох, үүнтэй холбогдуулан талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Алт-2” үндэсний хөтөлбөр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн А/66, А/202, А/174, А/166 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.
- 1.3 Энэ журмын хүрээнд Монголбанкнаас олгосон зээлийг банк алт олборлогч аж ахуйн нэгжид энэ журамд заасан нөхцөлөөр дамжуулан зээлдүүлнэ.
- 1.4 Банкнаас энэхүү журмын 1.3-т заасны дагуу алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлэх санхүүжилт нь тухайн аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой байна.
- 1.5 Монголбанкнаас банканд олгох зээлийн нийт хэмжээг Монголбанк Уул уурхай хүнд үйлдвэрийн яам (цаашид УУХҮЯ гэх)-наас ирүүлсэн санхүүжилтийн төслүүдэд үндэслэн тогтооно.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 Энэхүү журамд заасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1 “Санхүүжилт” гэж алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Монголбанкнаас оролцогч банкаар дамжуулан олгож буй хөнгөлөлттэй зээлийг;
 - 2.1.2 “Урьдчилгаа төлбөрийн санхүүжилт” гэж алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү журмын 3.2-т заасан нөхцөлтэйгөөр олгож буй богино хугацаатай хөнгөлөлттэй зээлийг;
 - 2.1.3 “Урт хугацаат санхүүжилт” гэж алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү журмын 3.3-т заасан нөхцөлтэйгөөр олгож буй урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийг;

- 2.1.4 “Оролцогч банк” гэж Монголбанкнаас олгосон санхүүжилтийг алт олборлогч аж ахуйн нэгжид дамжуулан зээлдүүлэх үүрэг хүлээсэн банкийг;
- 2.1.5 “Оролцогч алт олборлогч аж ахуйн нэгж” гэж оролцогч банкаар дамжуулан Монголбанкнаас санхүүжилт авсан алт олборлогч аж ахуйн нэгжийг;
- 2.1.6 “Санхүүжилтээр хүлээх үүрэг” гэж урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн хувьд Монголбанканд худалдахаар тохиролцсон алтыг;
- 2.1.7 “Санхүүжилтийн эргэн төлөлт” гэж урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн хувьд Монголбанкнаас олгосон санхүүжилтийн төлбөрийг, урт хугацаат санхүүжилтийн хувьд санхүүжилтийн үндсэн болон хүүний төлбөрийг хэлнэ.

ГУРАВ. САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 3.1 Санхүүжилт нь урьдчилгаа төлбөрийн санхүүжилт, урт хугацаат санхүүжилт гэсэн хоёр төрөлтэй байна.
- 3.2 Урьдчилгаа төлбөрийн санхүүжилт нь дараах нөхцөлтэй байна.
 - 3.2.1 Санхүүжилтээр хүлээх үүрэг нь оролцогч алт олборлогч аж ахуйн нэгжийн тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө (цаашид УАТ гэх)-гөөр олборлох алтны хэмжээнээс ихгүй байх.
 - 3.2.2 Санхүүжилтийн хэмжээ нь санхүүжилтээр хүлээх үүргийн төгрөгөөр илэрхийлэгдэх мөнгөн дүнгийн 30 хувиас ихгүй байх.
 - 3.2.3 Монголбанкнаас олгох урьдчилгаа төлбөрийн санхүүжилт нь 0 (тэг) хувийн хүүтэй байх бөгөөд банк 3 (гурав) хүртэл хувийг нэмж, дамжуулан зээлдүүлэх.
 - 3.2.4 Алт олборлогч аж ахуйн нэгжид олгох урьдчилгаа төлбөрийн санхүүжилт нь 6 сар хүртэл хугацаатай байх.
 - 3.2.5 Урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн эргэн төлөлт нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төлөгдсөн байх.
 - 3.2.6 Монголбанк урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг энэхүү журмын 2.1.2-т заасан зориулалтаар зөвхөн төгрөгөөр олгох.
 - 3.2.7 Урьдчилгаа төлбөрийн санхүүжилтээр хүлээх үүргийн төлөлт нь зөвхөн алтаар хийгдэх.
 - 3.2.8 Урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн эргэн төлөлт нь хугацааны эцэст төгрөгөөр хийгдэх.
- 3.3 Урт хугацаат санхүүжилт нь дараах нөхцөлтэй байна.
 - 3.3.1 Урт хугацаат санхүүжилт нь алт олборлогч аж ахуйн нэгжийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн талбай дахь алтны нөөцийн төгрөгөөр илэрхийлэгдэх мөнгөн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байх.
 - 3.3.2 Монголбанкнаас олгох урт хугацаат санхүүжилт нь бодлогын хүүтэй тэнцүү байх бөгөөд банк 3 (гурав) хүртэл хувийг нэмж, дамжуулан зээлдүүлэх.
 - 3.3.3 Алт олборлогч аж ахуйн нэгжид олгох урт хугацаат санхүүжилт нь 24 сар хүртэл хугацаатай байх.
 - 3.3.4 Монголбанк урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг энэхүү журмын 2.1.3-т заасан зориулалтаар зөвхөн төгрөгөөр олгох.
 - 3.3.5 Урт хугацаат санхүүжилтийн эргэн төлөлт нь урьдчилан тохиролцсон хуваарийн дагуу төгрөгөөр хийгдэх.

ДӨРӨВ. САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЧИМ

- 4.1 УУХҮЯ-наас энэхүү журмыг хэрэгжүүлэх хүрээнд уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийн шалгуурыг хангасан алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг гаргана. Уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдэлд:
 - 4.1.1 Ордын нөөцийн тайлан;
 - 4.1.2 Орд газрыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл;
 - 4.1.3 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;
 - 4.1.4 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө;

- 4.1.5 Бусад хууль, тогтоомжид заасан бусад бичиг баримт.
- 4.2 УУХҮЯ энэхүү журмын 4.1-д заасан жагсаалтыг гаргасан даруй Монголбанк болон банканд албан бичгээр хүргүүлнэ.
- 4.3 Алт олборлогч аж ахуйн нэгжид олгох урьдчилгаа төлбөрийн болон урт хугацаат санхүүжилтийн нөхцөлийг банк энэхүү журмын 3.2 болон 3.3 дахь заалттай нийцтэй байдлаар тодорхойлно.
- 4.4 Монголбанк нь банкны санхүүжилт дамжуулан зээлдүүлэх хүсэлт болон холбогдох бусад баримт бичигт үндэслэн уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийн шалгуурыг хангасан алт олборлогч аж ахуйн нэгжид оролцогч банкаар дамжуулан санхүүжилт олгоно.
- 4.5 Санхүүжилтийн хүүг тооцоходоо “бодит хуанлийн хоног/365” гэсэн аргачлалыг ашиглана.
- 4.6 Санхүүжилтийн төлбөр тооцоо хийгдэх өдөр нь амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр тохиовол дараагийн ажлын өдөр төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

ТАВ. МОНГОЛБАНКНЫ ЧИГ, ҮҮРЭГ

- 5.1 Монголбанк болон оролцогч банкны харилцааг зохицуулах ерөнхий гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.
- 5.2 Шаардлагатай тохиолдолд УУХҮЯ болон оролцогч алт олборлогч аж ахуйн нэгжээс санхүүжилттэй холбоотой мэдээ, мэдээлэл, тайлбарыг тухай бүр гаргуулан авна.
- 5.3 Засгийн газраас алт олборлолтын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, түүний хүлээгдэж буй үр дүн, тооцоо судалгаа үндэслэлийг УУХҮЯ-наас тухай бүр гаргуулан авна.
- 5.4 Оролцогч алт олборлогч аж ахуйн нэгжид олгосон санхүүжилтийн мэдээг сар бүрийн ажлын эхний 10 хоногт багтаан УУХҮЯ-нд хүргүүлнэ.
- 5.5 УУХҮЯ-ны хүсэлтийн дагуу оролцогч банктэй холбоотой асуудлыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд зайнаас болон газар дээрх шалгалтыг оролцогч банк дээр зохион байгуулна.

ЗУРГАА. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЧИГ, ҮҮРЭГ

- 6.1. Уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийг хангасан алт олборлогч аж ахуйн нэгжийн жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүр Монголбанк болон банканд албан бичгээр хүргүүлнэ.
- 6.2. Алт олборлогч аж ахуйн нэгжийн бичиг баримтын бүрдүүлэлтэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 6.3. Оролцогч алт олборлогч аж ахуйн нэгжийг УАТ-ний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажиллах бөгөөд зөрчлийг тухай бүр Монголбанканд мэдэгдэнэ.
- 6.4. Засгийн газраас алт олборлолтын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, түүний хүлээгдэж буй үр дүн, тооцоо судалгаа, үндэслэлийг тухай бүр Монголбанканд хүргүүлнэ.
- 6.5. Энэхүү санхүүжилтийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлөхүйц бодлогын шийдвэр гаргахдаа Монголбанканд мэдэгдэнэ.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Талууд санхүүжилтийн ашиглалтын явцад гарах аливаа асуудал, тус санхүүжилтийн хэрэгжилтийг боловсронгуй болгоход анхаарч харилцан зөвлөлдөж ажиллана.
- 7.2. Энэхүү санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг болон хэрэгжүүлэх арга, хэрэгсэлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Монголбанк болон УУХҮЯ хамтран шийдвэрлэнэ.
- 7.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**АЛТ АГУУЛСАН ХҮДЭР, ЭЛС ОЛБОРЛОН БАЯЖУУЛАХ, ХАМГААЛАХ,
ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ БОЛОН ХУДАЛДАХ ШААРДЛАГА**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Алт олборлон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь алт агуулсан хүдэр, элс олборлон баяжуулах, хадгалах, хамгаалах, хүлээлцэх, тээвэрлэх, худалдахтай холбоотой үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. АЛТ ХҮЛЭЭН АВАХ КОМИСС ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Алт олборлон баяжуулах үйлдвэрт алт хүлээн авах комисс томилж ажиллуулна. Алт хүлээн авах комиссыг /цаашид “Комисс” гэнэ/ тухайн аж ахуйн нэгжийн удирдлагын тушаалаар томилон ажиллуулах ба уг комисс нь энэхүү журмыг мөрдөн ажиллана.
- 2.2. Комиссын бүрэлдэхүүнд алтны нярав /кассчин/, баяжуулагч инженер, лабораторийн эрхлэгч, нягтлан бодогч, гэрээт харуул хамгаалалтын албаны ажилтан болон холбогдох бусад хүмүүсийг оруулах бөгөөд 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын бүрэлдэхүүнд нэг гэр бүлийн хүмүүсийг оруулахгүй байвал зохино.
- 2.3. Комиссын даргын эзгүйд түүнийг орлож ажиллах хүнийг тушаал гарган томилох бөгөөд комиссын дарга нь алттай холбогдолтой бичиг баримт /акт, журнал гэх мэт/-ыг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу найдвартай хадгалах үүрэгтэй.
- 2.4. Комисс нь алт баяжуулах үндсэн тоног төхөөрөмжүүдийн хамгаалалтын тор, түгжээ, лацыг шалган хүлээн авч онгойлгон баяжмалыг тусгай зориулалтын саванд хийж, лацдаж гүйцээн баяжуулах цехэд хоёрдугаар хавсралтын дагуу акт үйлдэн хүргэнэ.
- 2.5. Гүйцээн баяжуулах цехийг 24 цагийн ажиллагаатай хяналтын камераар тоноглогсон байна.
- 2.6. Алттай шлихийг гүйцээн баяжуулах цехэд хүлээн авч алтыг тунгааж, үлээсний дараа нүдэж нунтаглах, шаардлагатай бол зарим төрлийн уусмалд алтыг угаах зэрэг анхан шатны боловсруулалт хийж ялган авна.
- 2.7. Гүйцээн баяжуулах цехэд баяжмалаас алтыг ялгаж авсны дараа жинлэж актыг гуравдугаар хавсралтын дагуу үйлдэн алтны нярав /кассчин/-т тушаана.
- 2.8. Комисс нь алтыг жинлэн тусгай зориулалтын саванд хийж, 2-оос доошгүй хүний лацаар лацдаж сейфэнд хадгалж хамгаална.
- 2.9. Комисс нь Сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын улсын байцаагч шалгалт хийх, үнэт металлаас сорьцын шинжилгээнд дээж авах, алт, гулдмайг үйлдвэрийн талбайгаас гадагш гаргаж тээвэрлэх, борлуулалт хийх үйл ажиллагаанд байлцаж хүлээлгэн өгсөн актад гарын үсэг зурна.
- 2.10. Алт олборлон баяжуулах үйлдвэрт Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 281 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам”-ын 5.1-д заасны дагуу Үнэт металл олборлолтын журналыг хөтлөх, энэхүү журналын хуудсыг дугаарлан албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу үдэж, лац тэмдэг тавьсан байвал зохино.

ГУРАВ. АЛТ ХАДГАЛАХ

- 3.1. Алт хадгалах өрөө буюу алтны өрөө нь хулгайн эсрэг хамгаалсан нарийн боловсронгуй төхөөрөмжүүд болох камерын хяналтын систем, дохиоллын систем, хөдөлгөөн мэдрэгч, бусад хамгаалалтын хэрэгслүүдээр тоноглогдсон байна.

- 3.2. Тусгайлан тоноглож бэлтгэсэн өрөөнд байршуулсан хүндрүүлэгчтэй сейф буюу хана, шаланд бэхэлсэн зөөх боломжгүй, үл шатах авдарт алтыг хадгална.
- 3.3. Алт хадгалах өрөөнд зориулалтын хөдөлгөөнгүй суурин дээр байрлуулсан улсын баталгаатай жин хэмжүүр байх шаардлагатай.
- 3.4. Алтыг 0,01 нарийвчлалтайгаар жинлэж байна.
- 3.5. Алтыг зориулалтын металл бортогод, зориулалтын бортого байхгүй тохиолдолд ийм зориулалтаар ашиглаж болохуйц металл саванд хийж хадгалах бөгөөд бортого буюу металл савны тагийг лацадсан байна.
- 3.6. Алт хадгалдаг сейфийг нээж, хаахад комисс заавал бүрэн бүрэлдэхүүнээрээ байх бөгөөд сейфний түлхүүр, лацны тэмдгийг комиссын өөр өөр гишүүдэд хадгалуулна.
- 3.7. Алтыг хагарч бутрах шил, шаазан мэтийн саванд хадгалах, баталгаагүй жин хэмжүүрээр жинлэхийг хатуу хориглоно.
- 3.8. Алт олборлон баяжуулах үйлдвэрт алт угаах, гүйцээн баяжуулах цех, алт хадгалах өрөөнд заавал 24 цагийн ажиллагаатай хяналтын камер байна. Камерууд нь 24 цагийн турш бичлэг хийж түүнийгээ буцаан уншиж хянах боломжтой байна.

ДӨРӨВ. АЛТЫГ ХУДАЛДАХ, ХАМГААЛАХ, ТЭЭВЭРЛЭХ

- 4.1. Дөрвөн зуун /400/ граммаас доошгүй жинтэй байгалийнхаа хэлбэр дүрсээрээ байгаа эсвэл жин харгалзахгүй онцгой сонин дүрс хэлбэртэй цул алт олборлосон бол цул алтны бүртгэлд дөрөвдүгээр хавсралтын дагуу бүртгэн авч улмаар сорьцыг тогтоолгож, эсвэл сорьцыг тогтоолгох боломжгүй тохиолдолд тухайн ордын алтны дундаж сорьцоор тооцож Монгол банкны Эрдэнэсийн санд урамшуулалтай үнээр худалдах үүрэгтэй.
- 4.2. Сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын улсын байцаагчид нь олборлогч аж ахуйн нэгжийн тусгай комиссыг байлцуулан үнэт металл олборлолтын журналын хөтлөлт, кассын алтыг жинлэж шалгах эрх эдэлнэ.
- 4.3. Алт олборлон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрөлтэй хамгаалалтын албатай гэрээ байгуулан ажиллуулна.
- 4.4. Хамгаалалтын албыг ээлжээр ажиллуулахаар зохион байгуулах бөгөөд тэд алт олборлох, хадгалах, тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангаж гадна, дотны элдэв халдлагаас хамгаалах үүрэг хүлээнэ.
- 4.5. Алтыг хайлуулах, сорьц тогтоолгох, улсад тушаахаар авч явах үед олборлогч аж ахуйн нэгжийн тусгай комисс томилох бөгөөд уг комисст алт хүлээн авах комиссоос алтыг жинлэж хүлээлгэн өгч акт үйлдсэн байна.
- 4.6. Алтыг хайлуулах, сорьц тогтоолгох, улсад тушаахад байнгын хамгаалалттайгаар авч явах бөгөөд тухайн цаг хугацаа, маршрутыг уг ажилд шууд холбогдолгүй хүмүүст мэдээлэхийг хориглоно.
- 4.7. Олборлосон алтыг хайлуулах цехэд шилжүүлэхийн өмнө жинлэнэ. Алт хайлуулах үед олборлогч аж ахуйн нэгжийн тусгай комисс хамт байлцах бөгөөд хайлалтаас гарсан хаягдлыг олборлогч аж ахуйн нэгжийн тусгай комисс эргүүлэн авна. Хайлсан алтыг хөргөсний дараа дахин жинлэж хайлалтын актыг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 281 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам”-ын 4.2-д заасны дагуу үйлдэнэ.
- 4.8. Алт хайлуулах явцад гарсан хорогдлыг хайлалтын актад тодорхой тусгах бөгөөд хайлалтын явцад гарсан маргааныг холбогдох байгууллагууд хамтарч шийдэж чадахгүйд хүрвэл шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.
- 4.9. Сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар алтыг хайлуулсны дараа тус байгууллагын Үнэт металлын сорьц тогтоох итгэмжлэгдсэн лабораториор алтны сорьцыг тогтоолгож, баталгаажуулан худалдаална. Сорьц тогтоож, баталгаажуулах алтыг худалдаалахыг хориглоно.
- 4.10. Алт хайлах, сорьц тогтоох үйл ажиллагаатай холбогдсон маргаан гарвал Сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, шалтгааныг тогтоосны үндсэн дээр харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

- 4.11. Хяналт шалгалтын явцад алтны жингийн зөрүү гарвал шалтгааныг нарийвчлан тогтоосны үндсэн дээр акт тогтоож шийдвэрлэнэ. Харин жингийн зөрүүгийн шалтгаан нь ашиглан, шамшигдуулах хэлбэртэй байвал холбогдох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Алт олборлон баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь тухайн сард олборлосон металлын хэмжээг дараа сарын 05-ны дотор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд мэдээлж байх үүрэгтэй.
- 5.2. Алт олборлон баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь тухай жилд олборлосон үнэт металлын тайланг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 281 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам”-ын 5.2-д заасны дагуу гаргаж хянуулна.

---oOo---

Алт агуулсан хүдэр, элс олборлон
баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх
болон худалдах шаардлагын нэгдүгээр хавсралт

БАЯЖУУЛАХ ТӨХӨӨРӨМЖӨӨС АВСАН АЛТТАЙ БАЯЖМАЛЫГ
УГААЖ АЛТ ЯЛГАСАН ТУХАЙ АКТ №

.....оны.....сарын.....-ны өдөр

Комиссын дарга....., гишүүн.....

.....нарын

бүрэлдэхүүнтэй

комисс.....

(уурхайн нэр)

уурхайгаас оны сарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр
хүртлэх хугацаанд ялгасан алттай баяжмалыгоны.....сарын.....-ны өдрийн цагт
(алттай баяжмалын хэмжээг савны багтаамжаар бичих) авч алтыг жинлэж үзэхэд

..... /тоогоор/

.....грамм байлаа.

Актыг оны сарын-ны өдрийн цагт гүйцээн баяжуулах цехэд
хүлээлгэн өгөв.

АКТ ХҮЛЭЭН АВСАН КОМИСС:

ДАРГА.....

ГИШҮҮД.....

.....

.....

.....

Алт агуулсан хүдэр, элс олборлон
баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх
болон худалдах шаардлагын хоёрдугаар хавсралт

АЛТ ХҮЛЭЭН АВАХ АКТ №

20.....оны.....сарын.....-ны өдөр

20... оны ... сарын ...-ны өдөр олборлосон алтыг комисс дараах
бүрэлдэхүүнтэйгээр.....
.....хүлээн
авч анхны боловсруулалт хийж жинлэж үзэхэд дараах хэмжээтэй байв.
(бохир жин граммаар)

Баяжуулсан төхөөрөмжийн нэр	Комисс хүлээж авсан алтны жин	зөрүү (+), (-)	Боловсруулалт хийсний дараах жин		тайлбар
			Алтны жин	Хар шлихийн жин	

Хүлээн авсан кассын нярав.....

КОМИССЫН ДАРГА.....

ГИШҮҮД.....

.....

.....

.....

Алт агуулсан хүдэр, элс олборлон
баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх
болон худалдах шаардлагын гуравдугаар
хавсралт

.....
.....

(байгууллагын нэр)

ЦУЛ АЛТНЫ БҮРТГЭЛ

Ордын нэр	Цул алтны нэр	Цул алтыг олсон он сар өдөр	Цул алтны жин /гр/	Цул алт олсон хүний овог нэр, албан тушаал	Цул алт олж тушаасан хүний гарын үсэг	Цул алтны тодорхойлолт